



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 6/208

Улаанбаатар хот

Д.Батчулууныг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.3, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер Данзаншадарын Батчулуун /122357/-ыг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Д.Батчулуунд эрчим хүчний салбарт 17 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 22,848,000 /хорин хоёр сая, найман зуун дөчин найман мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Д.Батчулуунд нэг удаагийн тэтгэмжийн 22,848,000 /хорин хоёр сая, найман зуун дөчин найман мянга/ төгрөг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

4. Д.Батчулууны ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 20 хоногоор тооцож олгох, холбогдох тооцоог хийж дуусгахыг Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга /Д.Батжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН